

# ОЛОН ТАЛТ БАЙДЛЫГ ХАНГАЖ, ОРОЛЦООГ ДЭМЖИХ БОДЛОГО

## Ерөнхий мэдээлэл

Энэхүү бодлогод олон талт байдлыг хангах, оролцоог дэмжих хүрээнд CIMIC Группийн баримтлах зарчмуудыг тодорхойлсон. Энэ нь CIMIC Групп, түүний бүхий л салбар компанийн ажилтнууд, мөн тус Групптэй хамтран ажилладаг гуравдагч этгээдэд хамаарна.

## Бодлого

Олон улсын түвшний ажил олгогч болох CIMIC Групп нь үйл ажиллагаагаа амжилттай, тогтвортой явуулахын тулд дараах бодлогыг баримтлан ажиллана:

- Захиалагч, ажилтан, нийлүүлэгч, түслан гүйцэтгэгч болон орон нутгийн иргэдийг хүндэтгэж, эрх тэгш хандана;
- Оролцоог дэмжсэн туршлага, журам, дадал/зан төлөвийг хэвшүүлсэн ажлын орчныг бүрдүүлнэ;
- Нэг талыг баримтлаагүй, шударга шийдвэр гаргаж байна;
- Мэдлэг үр чадварыг харгалзан ажлын байр санал болгоно;
- Үндэс угсаа, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, гэр бүлийн байдал, шашин шүтлэг, арьсны өнгө, үндэсний онцлог, нийгмийн гарал, улс төрийн үзэл баримтлал, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүл, асран хамгаалагчийн үүрэг хариуцлага эсвэл жирэмсэн зэрэг шалтгаанаар ялгаварлан гадуурхахгүй;
- Үзэл бодол, туршлага, үр чадварын ялгаатай байдлыг ойлгож, дэмжиж байна;
- Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн захиалагчдын ялгаатай байдал, орон нутгийн онцлогт тохирсон ажиллах хүчний нөөцийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулна;
- Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгууд дах оролцогч талуудын хэрэгцээ шаардлага, ашиг сонирхлыг хүндэтгэж, шийдвэр гаргахдаа тэдгээрийг харгалзан үзнэ.

## Зорилго

CIMIC Групп нь ажилтнуудынхаа оруулж байгаа хувь нэмрийг ойлгож, хүндэтгэж, үнэлдэг гэдгээ батлан харуулж ажиллах зорилтын хүрээнд стратегийн дөрвөн гол зорилгыг тодорхойлсон.

Эдгээрт:

1. Группийн эмэгтэй ажилтнуудын оролцоог дэмжиж, сайжруулахаас гадна хүйсийн тэгш эрх, үүний дотор цалин хөлсний адил тэгш байдлыг хангана.
2. Уугуул иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, худалдан авалт хийхдээ нийлүүлэлтийн сүлжээн дэх уугуул иргэд, нийлүүлэгчдийг түлхүү ашиглана.
3. Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн ирээдүйн ажиллах хүчнийг бэлтгэх зорилгоор орон нутгийн ажилтнуудыг сургаж, чадавхжуулна.
4. Ажилтнуудын онцгой үр чадвар, авьяасыг хөгжүүлдэг, шударга, тэгш байдлыг хангасан ажлын орчныг бүрдүүлнэ.

CIMIC Групп нь гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд, явцын болон үнэлгээний тайлангуудаар дамжуулан энэхүү Бодлого болон түүний зорилтуудыг хянаж байна.

## Ашиглах материал

- Бодлогын хэрэгжилтийг хангахдаа Менежер нь Группийн ёс зүйн дүрэм, Ажилтныг сонгон шалгаруулж авах талаар баримтлах бодлого, Ажлын уян хатан нөхцөлөөр хангах журам зэрэг баримт бичигтэй танилцсан байх шаардлагатай.

## Бодлогын талаарх мэдээлэл

Эзэмшигч:	CIMIC Группийн Хүний нөөц хариуцсан захирал
Баталсан:	CIMIC Группийн ТУЗ-ийн дарга бөгөөд Гүйцэтгэх захирал
Хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх огноо:	2016 оны 1-р сарын 20

Жич: CIMIC Группийн бодлогод шаардлагатай үед өөрчлөлт орж болохыг анхаарна уу.